



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.3 дахь заалт, 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 03/09 дугаар албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 39 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Тус үнэт цаасны компанийн ирүүлсэн саналыг харгалзан 2016 оны 1, 2 дугаар улирлын гишүүнчлэлийн хөлсийг 2016 оны 4 дүгээр сарын 15-ны дотор, урд онуудын үлдэгдэл өр, төлбөрийг 2016 оны 5 дугаар сарын 31-ний дотор тус, тус төлж барагдуулахыг "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК /Н.Оюунтунгалаг/-д үүрэг болгосугай.
3. Үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээ шууд авахыг "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК /Н.Оюунтунгалаг/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР

000001